

ОЮУТНУУДЫН ДУНДАХ АНХААРАЛ ДУТМАГШИХ ХЭТ ХӨДӨЛГӨӨНТӨХ ЭМГЭГИЙГ ТАНДАХ НЬ

Л.Оюун-Эрдэнэ¹, Я.Билэгмаа¹, Д.Оюунцэцэг¹

¹АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль
oyunerdene@mnumns.edu.mn

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Л.Нарантуяа

Үндэслэл

Тодорхой объект буюу тодорхой үйл ажиллагаан дээр хүний ухамсрын үйл ажиллагаа чиглэн төвлөрч сэрэл, хүртэхүй, ой тогтоолт, сэтгэн бодох зэрэг сэтгэцийн үйл ажиллагааны илрэлийг анхаарал төвлөрөл гэх бөгөөд хүний ухамсар аливаа зүйлийг сонгож, тухайн зүйлд төвлөрөх чадамжийг анхаарал төвлөрөх чадвар гэнэ. Насанд хүрэгсдийн анхаарал төвлөрөлтийн дээд хугацаа 20-25мин байдаг. Биологийн шалтгаант зан үйлийн эмгэг буюу (D.Shaffer ба бусад эрдэмтэд) анхаарал төвлөрүүлэх чадваргүй хийгээд хэт хөтөлгөөнтөх шинжүүдээр илэрдэг сэтгэцийн эмгэгийг анхаарал дутмагших-хэт хөдөлгөөнтөх эмгэг гэнэ. (МУ-ын хүний гавьяат эмч, проф С.Бямбасүрэн). Анхаарал дутмагших-хэт хөдөлгөөнтөх эмгэг үүсэх шалтгаан тодорхойгүй боловч уг эмгэг үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс, зарим шалтгааныг төрөлхийн, удамшлын, хүрээлэн буй орчин буюу нийгмийн, биологийн хүчин зүйлс гэх мэт ангилдаг ба үүнээс 75%-ийг удамшлын хүчин зүйл эзэлдэг. Тус эмгэг нь анхаарал сулрах, хэт хөдөлгөөнтөх, өөрийн мэдэлгүй үйлдэл хийх гэсэн нийтлэг гурван шинжээр илэрнэ. Сурагчдийн хувьд анхаарал төвлөрөлт хангалтгүй шинжүүд: мартамхай, багшийн даалгавар биелүүлдэггүй, шинэ зүйл сурах хүлээн авахдаа муу, гэрийн даалгавараа бие даан хийх чадваргүй, унших, бодох, бичихдээ харьцангуй бэрхшээлтэй тулгардаг.

“Анхаарал дутмагших-хэт хөдөлгөөнтөх” эмгэг нь хүмүүсийн тэр болгон мэддэггүй боловч ноцтой эмгэг юм. Энэ төрлийн эмгэг өсвөр насны хүүхдүүдэд ихэвчлэн тохиолддог ба дэлхийн 19 хүртэлх насны хүүхдийн 3-5% нь анхаарал дутмагших-хэт хөдөлгөөнтөх эмгэг (АДХХЭ)-тэй, сургуулийн насны хүүхдийн 2-16%-д уг эмгэг оношлогдсон байна.

Түлхүүр үг: Анхаарал дутмагших-хэт хөдөлгөөнтөх, DSM-IV ангилал, өөрийгөө үнэлэх шалгуур, шинж тэмдгийн давтамж

Зорилго

Нэгдүгээр дамжааны оюутнуудын анхаарал дутмагших хэт хөдөлгөөнтөх эмгэгийг тодорхойлж, шинж тэмдгийн давтамжийг үнэлэх

Зорилт

1. Оюутнуудын дундах анхаарал дутмагших хэт хөдөлгөөнтөх эмгэгийг илрүүлэх
2. Анхаарал дутмагших хэт хөдөлгөөнтөх эмгэгийг шинж тэмдгийн давтамжийг үнэлэх

Материал, арга зүй

Иймээс бид энэхүү судалгаандаа 1-р дамжааны оюутнуудын анхаарал дутмагших хэт хөдөлгөөнтөх эмгэгийг судлахын тулд DSM-IV ангилалд суурилсан асуумж бүхий насанд хүрэгчдийн анхаарал дутмагших-хэт хөдөлгөөнтөх эмгэгийн өөрийгөө үнэлэх шалгуур (ASRS-v1.1)-аар тодорхойлсон болно. Судалгааны асуулгын хуудас 2 бүлэг, 18 асуулт бүхий DSM-IV ангилалд суурилсан шинж тэмдгийн хяналтын хуудасны загвараар боловсруулсан хоёр хэсгээс бүрдэх бөгөөд А хэсэг нь анхаарал дутмагших-хэт хөдөлгөөнтөх эмгэгийг урьдчилан таамаглана. Б хэсэг бол өвчний шинж тэмдгийн давтамжийг судлах ач холбогдолтой юм. Судалгааны статистик боловсруулалтыг SPSS 24 програм ашиглан хийв.

Шинэлэг тал Энэ талаар хийгдсэн олон судалгаа байдаг ч нэгдүгээр дамжааны оюутнуудын анхаарал дутмагших хэт хөдөлгөөнтөх эмгэг, эмнэл зүйн шинжийг DSM-IV-т суурилсан асуумжийн аргаар шалгаж, боловсруулсан нь шинэлэг юм. **Практик ач холбогдол** Судалгааны үр дүнд үндэслэн цаашид АДХХЭ-тэй байж болзошгүй оюутнуудын өдөр тутмын амьдрал, бусадтай харилцах явцад гарах саад бэрхшээл, сурч боловсрох хэв маягт мэргэжлийн үүднээс хандах боломжийг бий болгох санал дэвшүүлж байгаад судалгааны ажлын практик ач холбогдол оршино.

Үр дүн

Судалгаанд 17-26 хүртэл насны нийт 200 оюутнууд хамрагдсан ба насны дундаж үзүүлэлт 18.24±20.15 байв. Эмэгтэй 90%, эрэгтэй 10% байв.



Зураг 1. Судалгаанд хамрагдсан оюутнуудыг суралцаж буй мэргэжлээр харуулбал

Оюутнуудаас DSM-IV ангилалд суурилсан асуумж бүхий насанд хүрэгчдийн анхаарал дутмагших-хэт хөдөлгөөнтөх эмгэгийг илрүүлэх өөрийгөө үнэлэх шалгуур(ASRS-v1.1)-ын А хэсэг буюу зураг 2-оос харахад суралцах хэв маягт өгсөн өөрийн үнэлгээг тодруулахад хувь хүний үүрэг хариуцлага хамгийн чухал 74%, сургалтын явц болон төгсгөлд мэдлэг шалгах сорилыг ажиллахад

бэрхшээл тулгардаг 61%, аливааг хийх бодол хүслээсээ татгалзах, түр зайлсхийх, хойшлуулах байдал 59%, асуудлыг шийдэх явцад өөр зүйл хийх, анхаарал саринах байдал гардаг 58,8%, удаан хугацаагаар суух тохиолдолд гар, хөлөөрөө оролддог 55% заримдаа, ихэвчлэн болон байнга гэж хариулсан байв.



Зураг 2. Суралцах хэв маягт өгсөн өөрийн үнэлгээ

Оюутнууд АДХХЭ-ийг шинж тэмдгийн давтамжид өгсөн үнэлгээг хүснэгт 1-ээс харахад бодит байдалд анхаарлаа төвлөрүүлэхэд бэрхшээлтэй байдалд нийт 48%, 3 оноог 20,5%, сургалт, уулзалтын үед удаан суухад бэрхшээлтэй

байдалд 66%, 4 оноог 29,5%, ихэвчлэн хэт их ярьдаг байдалд 62%, 3 оноог 32%, бусадтай ярилцах үед яриаг нь таслах үйлдэл гаргадаг байдалд 47,5%, 3 оноог 23,5% тус тус өгсөн байв.

Хүснэгт 1. Шинж тэмдгийн давтамжийн үнэлгээ

Үнэлгээ	Бодит байдалд анхаарлаа төвлөрүүлэхэд бэрхшээлтэй юу?	Сургалт, уулзалтын үед удаан суухад хэр бэрхшээлтэй вэ?	Ихэнх тохиолдолд хэт их ярьдаг уу?	Бусадтай ярилцах үед яриаг таслах үйлдэл гаргадаг уу?
1 оноо	20.5%	7%	14.5%	28.5%
2 оноо	29.5%	27%	23.5%	24%
3 оноо	20.5%	28%	32%	23.5%
4 оноо	18.5%	29.5%	21%	12%
5 оноо	9%	8.5%	9%	12%

Дүгнэлт

- Оюутнуудаас анхаарал дутмагших-хэт хөдөлгөөнтөх эмгэгийг илрүүлэх өөрийгөө үнэлэх шалгуур(ASRS-v1.1)-ын А хэсэгт өгсөн үнэлгээг харахад хувь хүний үүрэг хариуцлага хамгийн чухал гэж 74%, сургалтын явц болон төгсгөлд мэдлэг шалгах сорилыг ажиллахад бэрхшээл тулгардаг гэж 61% гэж хариулжээ.
- Шинж тэмдгийн давтамжийн байдалд дүгнэлт хийхэд анхаарал дутмагших хэлбэрт бодит байдалд анхаарлаа төвлөрүүлэхэд бэрхшээлтэй гэж 48%(2.6±1.2), хэт хөдөлгөөнтөх хэлбэрт удаан сууж чаддаггүй 66%(3±1.08), хэт их ярьдаг гэж 62%(2.8±1.1) тохиолдолд илэрсэн ба эдгээр нь хамгийн их тохиолддог шинжүүд байлаа.

Ном зүй

- С.Бямбасүрэн. “Сэтгэцийн эмгэг судлал”. 2002 он: х748-750
- Суборинова.Н.Ю. Гиперактивность с дефицитом внимания: факторы риска, возрастная динамика, особенности диагностики. Дефектология,. 2003: №6.
- Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв. “Хэт хөдөлгөөнтөх эмгэгийн оношлогоо, эмчилгээний стандарт” (MNS 5481-7:2005). УБ 2005
- Д.Малчинхүү. “Хүүхдийн өвчин”. Улаанбаатар Соёмбо принтинг, 2011, х540-541.
- Wisniewska B. “The assessment of comorbid disorders in ADHD children and adolescent”. Advances in Medical Sciences. 2007
- <http://www.webmd.com/baby/20110421/pesticide-exposure-in-womb-linked-to-lower-iq>